



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/1398.

Улаанбаатар хот

「 Хан-Уул дүүргийн 67 дугаар цэцэрлэгийн
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хан-Уул дүүргийн 67 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 3 нэр төрлийн нийт 76,547,730.00 (далан зургаан сая таван зуун дөчин долоон мянга долоон зуун гучин) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн 67 дугаар цэцэрлэг (С.Мөнхцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 3 нэр төрлийн 76,547,730.00 (далан зургаан сая таван зуун дөчин долоон мянга долоон зуун гучин) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг устгалын акт үйлдэн устгахыг Хан-Уул дүүргийн 67 дугаар цэцэрлэг (С.Мөнхцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн хамтартын 2024 оны 10-дүгээр сарын 19-ний өдрийн 0/398 дугаар т

Байгууллагын нэр: Нийслэлийн Хан-Уул дүүргийн 67 дугаар цэцэрлэг

[illegible]